

I-III/2021

Тархаасан: 2021 оны 05 дугаар сарын 11




## Зочид буудлын салбарын үйлдвэрлэгчийн үнэ өмнөх улирлаас 0.6 хувиар буурлаа

Зочид буудлын салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс (2015=100) 2021 оны 1 дүгээр улиралд 130.0 болж, үнэ өмнөх оны мөн үеэс 1.6 хувь, өмнөх улирлаас 0.6 хувиар тус тус буурсан байна.

Нийтийн хоолны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс (2015=100) 2021 оны 1 дүгээр улиралд 106.9 болж, үнэ өмнөх оны мөн үеэс 0.4 хувь, өмнөх улирлаас 0.2 хувиар тус тус өссөн байна.

Зураг 1. Зочид буудал, нийтийн хоолны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс (2015=100), улирлаар, хувиар



Зочид буудлын салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс өмнөх улирлаас 0.6 хувиар буурахад богино хугацаагаар байр, сууцаар хангах үйл ажиллагааны дэд салбарын үйлдвэрлэгчийн үнэ 0.6 хувиар буурсан нь голлон нөлөөллөө.

Хүснэгт 1. Зочид буудлын салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс, дэд салбараар, хувиар

Дэд салбар	2021 I-III	2021 I-III	2021 I-III
	2015	2020 I-III	2020 X-XII
Ерөнхий индекс	130.0	98.4	99.4
Богино хугацаагаар байр, сууцаар үйлчлэх үйл ажиллагаа	129.9	98.2	99.4
Автомашинны зогсоол бүхий зуслан, чөлөөт цаг өнгөрөөх хоноглох байраар хангах үйл ажиллагаа	159.4	120.8	99.4
Бусад төрлийн байраар хангах үйл ажиллагаа	98.0	75.6	100.0

Нийтийн хоолны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар өсөхөд аймгуудын нийтийн хоолны үйлчилгээ эрхлэгч ААН-ийн үйлдвэрлэгчийн үнэ 2.9 хувиар өссөн нь голлон нөлөөллөө.

Хүснэгт 2. Нийтийн хоолны салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс, аймаг, нийслэлээр, хувиар

Дэд салбар	2021 I-III	2021 I-III	2021 I-III
	2015	2020 I-III	2020 X-XII
	2015=100		
Ерөнхий индекс	106.9	100.4	100.2
Нийслэл	106.6	100.0	100.0
Аймаг	109.3	102.9	101.3

### Ойлголт, тодорхойлолт:

Үйлдвэрлэгчийн үнийн индекс (ҮҮИ): Тухайн үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг илэрхийлнэ.

Индексийн жин: Индексийн тооцоонд ашиглах жинг тухайн бүтээгдэхүүний нийт борлуулалтын хэмжээнд эзэлж буй хувийн жингээр тооцно.

### Тооцох аргачлал:

ҮҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийг хэрэглэнэ. Үүнд:

$$I_p^t = \frac{\sum_{i=1}^n (p_t^i * q_0^i)}{\sum_{i=1}^n (p_0^i * q_0^i)}$$

$I_p^t$  - t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

t – Тайлант үе

0 – Суурь үе

$p_t^i$  – i барааны тайлант үеийн үнэ

$p_0^i$  – i барааны суурь үеийн үнэ

$q_0^i$  - i барааны суурь үеийн худалдан авсан тоо

**Эх үүсвэр:** ҮСХ, Зочид буудал, нийтийн хоолны салбарын үйлдвэрлэгчийн үнийн мэдээ

**Ангилал, код:** Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал, Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн ангилал

**Мэдээлэл авах линкүүд:**

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ тархаах хуваарь:** 2021 оны 07 дугаар сарын 19



Эдийн засгийн статистикийн газрын  
дарга Э.Эрдэнэсан  
Утас : (976-51)-266414

Эдийн засгийн статистикийн газрын  
статистикч Г.Мөнх-Оргил  
Утас : (976-51)-261561